



Үндэсний Татварын
Ерөнхий Газар

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР



**ШИНЭ ХУУЛИАР
ТАТВАР БУУРЛАА**



2007 0Н

ӨМНӨХ ҮГ

Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан татварын багц хуулиудыг 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэллээ. Эдгээр хуулиудаас Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг та бүхэнд толилуулж байна. Шинэ хууль агуулгын хувьд өмнө нь мөрдөж байсан хуулиас ихээхэн шинэчлэгдсэнийг тэмдэглэж байна.

Шинэ хуулиар бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, ажлын байр бий болгох, татварын тэгш шударга байдлыг хангах, хуулийг энгийн хялбар болгож нэг мөр ойлгох, олон улсын жишигт нийцүүлэх алхмуудыг авч хэрэгжүүллээ.

Хуулийг иргэдэд ойлгомжтой тайлбарлах үүднээс шинэ хуулийн заалтуудыг өмнө нь мөрдөж байсан хуулийн заалтуудтай харьцуулсан хүснэгтийг товхимолд тусгалаа. Та хуулийг бүрэн эхээр нь Үндэсний татварын албаны www.mta.mn вэб хуудаснаас уншиж танилцаж болох юм. Мөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн маягтууд, тэдгээрийг нөхөх заавар зэрэг танд хэрэгтэй мэдээллийг товхимолд тусгалаа.

Та уг товхимлын цахим хувилбарыг манай вэб хуудас (www.mta.mn) - аас авч ашиглах боломжтой бөгөөд цаашид гаргах мэдээллийг илүү үр өгөөжтэй болгох үүднээс Таны саналыг бид өөрийн вэб хаягаар хүлээн авахад таатай байх болно.

ДАРГА



Л. ЗОРИГ

ГАРЧИГ

ХУУЛИЙН ЗААЛТУУД	1-14
Албан татвар төлөгч.....	2
Оршин суугч	2
Оршин суугч бус	2
Оршин суух статус - татварын ялгаа.....	2
Харилцан хамаарал бүхий этгээд.....	4
Албан татвар ногдох орлого.....	4
Хасагдах зардлууд.....	6
Хязгаарлалттай хасагдах зардлууд.....	8
Хасагдахгүй зардлууд.....	8
Элэгдэл, хорогдол.....	10
Чөлөөлөгдөх орлого.....	10
Албан татварын хувь, хэмжээ.....	12
Албан татварын хөнгөлөлт.....	12
Алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох.....	14
Татварын амралт.....	14
АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАН	15-17
Тайлангийн маягт нөхөх заавар.....	18-19
СУУТГАГЧИЙН ТАЙЛАН №1	20
СУУТГАГЧИЙН ТАЙЛАН №2	21-22
Суутгагчийн тайлан №2 нөхөх заавар.....	23-24
СУУТГАГЧИЙН ТАЙЛАН №3	25
СУУТГАГЧИЙН ТАЙЛАН №4	26

ХУУЧИН ХУУЛЬ

Албан татвар төлөгч	<ul style="list-style-type: none"> ◆ Компани, хоршоо, нөхөрлөл, гадаадын дагнасан болон хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж ◆ гадаадын аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газар ◆ арилжааны банк, зээл, даатгалын болон тэдгээртэй адилтгах бусад байгууллага ◆ төрийн бус байгууллага ◆ шашны байгууллага ◆ төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд ◆ оршин суугч бус хуулийн этгээд ◆ дээр зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд
Оршин суугч	<ul style="list-style-type: none"> ◆ тодорхойлолт байгаагүй
Оршин суугч бус	<ul style="list-style-type: none"> ◆ төлөөлөгчийн газраараа дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж: <ul style="list-style-type: none"> • аж ахуйн үйл ажиллагаагаа бүрэн буюу хэсэгчлэн хэрэгжүүлж буй татвар төлөгчийн байнгын байр • барилгын талбай, монтаглах буюу угсрах объект, түүнчлэн эдгээр объектуудтай холбоотой хяналтын үйл ажиллагаа • байгалийн нөөц баялгийг эрж хайх зориулалттай тоног төхөөрөмж, барилга байгууламж, өрөмдлөгийн цамхаг, үүнтэй холбоотой хяналтын үйл ажиллагаа • худалдаа хийх, үйлчилгээ үзүүлэх газар
Оршин суух статусын татварын ялгаа	<ul style="list-style-type: none"> ◆ төлөөлөгчийн газрын зөвхөн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж олсон орлогод албан татвар ногдоно ◆ бусад татвар төлөгчийн гадаад улсад олсон орлогын талаар хуульд тодорхой заалт байхгүй.

ШИНЭ ХУУЛЬ

Албан татвар төлөгч	<ul style="list-style-type: none"> ◆ Дотоод, гадаадын компани, нөхөрлөл, хоршоо ◆ төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
Оршин суугч	<ul style="list-style-type: none"> ◆ Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж; ◆ удирдах байгууллага нь Монгол Улсад байрладаг гадаадын аж ахуйн нэгж.
Оршин суугч бус	<ul style="list-style-type: none"> ◆ төлөөний газраараа дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж: <ul style="list-style-type: none"> • салбар/цех, тасаг/; • үйлдвэр; • худалдаа, үйлчилгээний газар; • газрын тос, байгалийн хийн цооног, түүнчлэн ашигт малтмал олборлож буй аливаа уурхай ◆ бусад хэлбэрээр Монгол Улсад орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж
Оршин суух статусын татварын ялгаа	<ul style="list-style-type: none"> ◆ Монгол Улсад байнга байрладаг татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт болон гадаад улсад олсон орлогод албан татвар ногдоно ◆ Монгол Улсад байнга байрладаггүй татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж олсон орлогод албан татвар ногдоно

ХУУЧИН ХУУЛЬ

<p>Харилцан хамаарал бүхий этгээд</p>	<ul style="list-style-type: none"> ◆ Заалт байгаагүй. Гэвч зах зээлийн үнээс доогуур үнээр хийгдсэн гүйлгээг дахин үнэлэх тухай ерөнхий заалт бий.
<p>Албан татвар ногдох орлого</p>	<ul style="list-style-type: none"> ◆ Дараах орлого: <ul style="list-style-type: none"> • үндсэн болон туслах үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний орлого • арилжааны банкны болон зээлийн үйл ажиллагааны орлого • даатгалын үйл ажиллагааны орлого • бирж, брокерын үйл ажиллагааны орлого • барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны орлого • хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогын цэвэр дүн • үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогын нийт дүн • эрхийн шимтгэлийн орлого • хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлого • зээллэгийн хүүгийн орлого • хөрөнгө түрээслүүлсний орлого • зуучлах үйл ажиллагааны орлого • хонжворт сугалаа, таавар, тоглоомын орлого • банкнаас авсан хүүгийн орлого • гадаад валютын арилжаанаас олох орлого • албан татвар ногдох бусад орлого.

ШИНЭ ХУУЛЬ

<p>Харилцан хамаарал бүхий этгээд</p>	<ul style="list-style-type: none"> ◆ Харилцан хамаарал бүхий этгээд гэж: <ul style="list-style-type: none"> • энгийн хувьцааных нь 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг • ногдол ашиг, ашгийн хуваарилалтынх нь 20 буюу түүнээс дээш хувийг авах эрхтэй • аж ахуйн нэгжийн удирдлагын 20 буюу түүнээс дээш хувийг томилох эрхтэй, эсхүл үйл ажиллагааных нь бодлого чиглэлийг тодорхойлдог ◆ тухайн гүйлгээг харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийгдэх жишиг үнээр үнэлнэ (бенчмарк үнэ) ◆ жишиг үнэ хэрэглэх аргачлалыг Сангийн сайд батална.
<p>Албан татвар ногдох орлого</p>	<ul style="list-style-type: none"> ◆ Үйл ажиллагааны орлого: <ul style="list-style-type: none"> • үндсэн болон туслах үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого; • эрх борлуулсны орлого; • хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого; • төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого; • эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэг худалдсан буюу төлбөртэй ашиглуулсан, эсхүл эротик тоглолт явуулсан үйлчилгээний орлого; • үнэ төлбөргүйгээр бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээний орлого; • биет бус хөрөнгө борлуулсны орлого; • техникийн, удирдлагын, зөвлөх болон бусад үйлчилгээний орлого; • гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй этгээдээс авсан хүү, анз /торгууль, алданги/, хохирлын нөхөн төлбөрийн орлого; • гадаад валютын ханшны зөрүүгийн бодит орлого; • адилтгах бусад орлого. ◆ хөрөнгийн орлого: <ul style="list-style-type: none"> • хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн орлого; • эрхийн шимтгэлийн орлого; • ногдол ашгийн орлого; • хүүгийн орлого ◆ хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого

ХУУЧИН ХУУЛЬ

Хасагдах зардлууд	<ul style="list-style-type: none"> ◆ цалин, хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл хөлс ◆ бүх төрлийн бараа, материал ◆ эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл ◆ элэгдэл, хорогдлын шимтгэл ◆ урсгал засварын зардал ◆ барилгын төсөвт тусгагдсан шагнал ◆ гадаадын валютын арилжаанаас гарах алдагдал ◆ бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс ◆ түрээсийн төлбөр ◆ зээлийн хүү ◆ хөрөнгө эзэмшигчдээс тогтоосон хэмжээний захиргааны зардал ◆ татвар: <ul style="list-style-type: none"> • онцгой албан татвар • үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар • автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар • газар, байгалийн нөөц ашигласны хураамж ◆ санхүүгийн байгууллагын эрсдэлийн санд төвлөрсөн хөрөнгө ◆ заавал даатгалын хураамж
--------------------------	---

ШИНЭ ХУУЛЬ

Хасагдах зардлууд	<ul style="list-style-type: none"> ◆ бүх төрлийн бараа, материал ◆ нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар ногдуулан төлсөн цалин, хөдөлмөрийн үндсэн ба нэмэгдэл хөлс ◆ эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл ◆ ажиллагчдад олгосон шагнал, урамшуулал, байр, орон сууцны хөлс болон унаа, хоол, түлшний үнийн хөнгөлөлт ◆ үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэл ◆ урсгал засварын зардал ◆ үндсэн болон туслах үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэх, эд хөрөнгө худалдан авах зорилгоор авсан зээлийн хүү ◆ гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит алдагдал ◆ бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс ◆ түрээсийн төлбөр ◆ санхүүгийн түрээсийн төлбөрийн хүү ◆ мэргэжлийн сонин, сэтгүүлийн захиалга ◆ заавал болон сайн дурын даатгалын хураамж ◆ татвар: <ul style="list-style-type: none"> • онцгой албан татвар • үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар • гэнэтийн ашгийн татвар • гаалийн тариф • автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар • газар, байгалийн нөөц ашигласны хураамж ◆ хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг хоршоо, бусад хоршоо, банк, банк бус санхүүгийн байгууллагын болзошгүй алдагдлын санд төвлөрүүлсэн хөрөнгө ◆ зар сурталчилгааны зардал ◆ ажиллагчдын сургалт, давтан сургалтын зардал ◆ үр бордоо, мал, амьтны тэжээл, эм тарилга, ургамал хамгааллын арга хэмжээнд зарцуулсан зардал ◆ тээврийн зардал ◆ бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл худалдан авсан зардал ◆ хөдөлмөр хамгааллын зардал ◆ холбоо, бичиг хэрэг, цэвэрлэгээ, харуул хамгаалалтын ◆ Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан гамшгийн улмаас учирсан хохирлыг арилгахад гарсан зардал ◆ бараа, материалын хэвийн хорогдол ◆ Ашигт малтмалын тухай хуульд заасан байгаль орчныг нөхөн сэргээх зорилгоор төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө
--------------------------	---

ХУУЧИН ХУУЛЬ

Хязгаарлалттай хасагдах зардлууд	<ul style="list-style-type: none"> ◆ зар сурталчилгаа, сургалтын зардал татвар ногдуулах орлогын 10 хувиас хэтрэхгүй ◆ харилцан хамаарал бүхий талуудын зээлийн хүүгийн зардал хувь нийлүүлсэн хөрөнгийн 30 хувиас хэтрэхгүй
Хасагдахгүй зардлууд	<ul style="list-style-type: none"> ◆ баримтаар нотлогдоогүй зардал ◆ хөрөнгө оруулалт ◆ их засварын зардал (капиталжуулна) ◆ бүх төрлийн шагнал, урамшуулал, тэтгэмж ◆ бусдад өгсөн хандив, бэлэг дурсгал ◆ хүлээн авалт ◆ хэвлэл захиалга ◆ байр, орон сууцны хөлсний болон унаа, хоол, байр түлшний үнийн хөнгөлөлт ◆ материалын хэвийн хорогдол ◆ хугацаа хэтэрсэн зээлийн хүү ◆ бусдад учруулсан хохирлыг нөхсөн төлөөс

ШИНЭ ХУУЛЬ

Хязгаарлалттай хасагдах зардлууд	<ul style="list-style-type: none"> ◆ үл хөдлөх эд хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 2 хувиас хэтрэхгүй ◆ бусад хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 5 хувиас хэтрэхгүй ◆ сайн дурын даатгалын хураамж албан татвар ногдуулах орлогын 15 хувиас хэтрэхгүй ◆ албан томилолтын зардал төрийн албан хаагчдын албан томилолтын зардлыг 2 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй ◆ хөрөнгө оруулагчийн олгосон зээлийн тухайн хөрөнгө оруулалтын хэмжээнээс 3 дахин хэтэрсэн хэсэгт тооцсон хүүг хасахгүй.
Хасагдахгүй зардлууд	<ul style="list-style-type: none"> ◆ бүх татвар төлөгчид: <ul style="list-style-type: none"> • албан татвараас чөлөөлөгдөх орлого олоход гарсан зардал • баримтаар нотлогдоогүй зардал • суутган тооцох шаардлагатай боловч албан татвар суутгаагүй төлбөр • санхүүгийн түрээсийн төлбөр • албан татвар төлөгчийн буруутай үйл ажиллагаатай холбогдон төлсөн торгууль, алданги, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлсөн төлбөр ◆ оршин суугч бус татвар төлөгчид: <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна гарсан зардал • тухайн орлогыг олоход хамааралгүй, удирдлагын болон захиргааны зардал

ХУУЧИН ХУУЛЬ

<p>Элэгдэл, хорогдол</p>	<ul style="list-style-type: none"> ◆ хуваарийн дагуу шулуун шугамын аргаар байгуулна: <ul style="list-style-type: none"> • барилга, байгууламж: 40 жил • машин, механизм, техник, тоног төхөөрөмж компьютер: 10 жил • тусгай зориулалтын машин, техник, тоног төхөөрөмж: 5 жил • бусад үндсэн хөрөнгө: 10 жил ◆ газар, бараа, материалын нөөцөд элэгдэл, хорогдлын шимтгэл тооцохгүй
<p>Чөлөөлөгдөх орлого</p>	<ul style="list-style-type: none"> ◆ Засгийн газрын өрийн бичгийн /бонд/ хүү ◆ төрийн бус байгууллагын гишүүд, дэмжигчдийн татвар, хандив ◆ нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангийн орлого ◆ Монголбанкны орлого ◆ нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын орлого ◆ авто зам, замын байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан, засвар, арчлалт хийсэн аж ахуйн нэгжийн уг ажилд зарцуулсан хөрөнгө ◆ газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах зарчмаар үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж ◆ гадаадын хөрөнгө оруулагчийн хийсэн дахин хөрөнгө оруулалт

ШИНЭ ХУУЛЬ

<p>Элэгдэл, хорогдол</p>	<ul style="list-style-type: none"> ◆ хуваарийн дагуу шулуун шугамын аргаар байгуулна <ul style="list-style-type: none"> • барилга, байгууламж: 40 жил • машин, механизм, техник, тоног төхөөрөмж: 10 жил • компьютер, түүний эд анги, программ хангамж: 3 жил • бусад үндсэн хөрөнгө: 10 жил • биет бус хөрөнгө: 10 жил, эсхүл ашиглагдах хугацаа ◆ засварын зардлын зөвшөөрсөн хэмжээнээс хэтэрсэн хэсгийг хөрөнгийн үлдэгдэл өртөгт тооцож элэгдүүлнэ ◆ уул уурхайн үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтцэд зарцуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг тэдгээрийн ашиглагдах хугацаанд тооцно ◆ ашиглагдахгүй үндсэн хөрөнгийг борлуулсанд тооцно ◆ санхүүгийн түрээсийн хөрөнгөд элэгдэл тооцно ◆ барилга байгууламж барих, тоног төхөөрөмж угсрах, суурилуулах хугацаанд гарсан зээлийн хүүгийн зардлыг капиталжуулна ◆ газар, бараа, материалын нөөцөд элэгдэл, хорогдлын шимтгэл тооцохгүй
<p>Чөлөөлөгдөх орлого</p>	<ul style="list-style-type: none"> ◆ Засгийн газрын өрийн бичгийн /бонд/ хүү ◆ газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа оршин суугч бус татвар төлөгч ◆ гишүүдийнхээ бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагааны зуучлалын үнийн зөрүүгээс олсон хоршооны орлого

ХУУЧИН ХУУЛЬ

Албан татварын хувь, хэмжээ	<ul style="list-style-type: none"> ◆ 100 сая хүртэл 15%, түүнээс дээш 30% ◆ ногдол ашгийн орлогод 15% ◆ эрхийн шимтгэл 10% ◆ төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлогод 40% ◆ видео, аудио хуурцгийн үйлчилгээний орлого 40% ◆ үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогын дүнд 2% ◆ хүүгийн орлогод 15% ◆ оршин суугч бус хуулийн этгээдийн Монгол Улсад олсон дараахь орлогод 20%: <ul style="list-style-type: none"> • ногдол ашиг • зээлийн хүү, батлан даалт гаргасны төлбөр • эрхийн шимтгэлийн орлого, түрээсийн төлбөр • техникийн болон бусад үйлчилгээний орлого ◆ оршин суугч бус татвар төлөгч өөрт ногдох ашгаасаа гадаадад шилжүүлбэл шилжүүлсэн ашгийн 20% ◆ Шашны байгууллага 20%
Татварын хөнгөлөлт	<ul style="list-style-type: none"> ◆ үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлээс олсон орлогод ногдох албан татварыг 50% ◆ хөдөлмөрийн чадвараа алдсан хvн ажилладаг хуулийн этгээдийн орлогын албан татварыг тухайн хуулийн этгээдийн нийт ажиллагсдад тахир дутуу хvний эзэлж байгаа хувиар

ШИНЭ ХУУЛЬ

Албан татварын хувь, хэмжээ	<ul style="list-style-type: none"> ◆ 3.0 тэрбум хүртэл 10%, түүнээс дээш 25% ◆ ногдол ашгийн орлогод 10% ◆ эрхийн шимтгэл 10% ◆ төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлогод 40% ◆ эротик материал зарах, түрээслүүлэх орлогод 40% ◆ эротик тоглолт явуулсан үйлчилгээний орлогод 40% ◆ үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогын дүнд 2% ◆ хүүгийн орлогод 10% ◆ эрх борлуулсны орлогод 30% ◆ гадаадын аж ахуйн нэгжийн ногдох ашгаасаа гадаадад шилжүүлбэл шилжүүлсэн ашгийн 20% ◆ оршин суугч бус хуулийн этгээдийн Монгол Улсад олсон дараахь орлогод 20%: <ul style="list-style-type: none"> • ногдол ашиг • хүүгийн орлого • эрхийн шимтгэлийн орлого, түрээсийн төлбөр • удирдлагын зардалд төлсөн төлбөр • Монгол Улсын нутаг дэвсгэр дээр борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний орлого
Татварын хөнгөлөлт	<ul style="list-style-type: none"> ◆ үр тариа, төмс, хүнсний ногоо, сүү, жимс жимсгэнэ, тэжээлийн ургамлын үйлдвэрлэлээс олсон орлогод ногдох албан татварыг 50% ◆ 10%-ийн хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлтийг 3 жил шилжүүлэн тооцно: <ul style="list-style-type: none"> • үндсэн хөрөнгө • тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт үйлдвэрлэл, үйлчилгээг шинээр бий болгох, эсхүл эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх, шинэчлэх зорилгоор • 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хөрөнгө оруулсан ◆ хөдөлмөрийн чадвараа алдсан иргэн ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажиллагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эзэлж байгаа хувь хэмжээгээр ◆ давхар татварын гэрээтэй гадаад улсад төлсөн татвар

ХУУЧИН ХУУЛЬ

Алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох	<ul style="list-style-type: none"> ◆ заалт байгаагүй
Татварын амралт: 10 жил 100%, 5 жил 50%	<ul style="list-style-type: none"> ◆ гадаадын хөрөнгө оруулалттай: <ul style="list-style-type: none"> • цахилгаан, дулааны станц • цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ • агаарын тээвэр, инженерийн байгууламж • телекоммуникацийн үндсэн сүлжээ • эрчим хүчний эх үүсвэр барих • технологийн шинэчлэл
Татварын амралт: 5 жил 100%, 5 жил 50%	<ul style="list-style-type: none"> ◆ гадаадын хөрөнгө оруулалттай: <ul style="list-style-type: none"> • нефть, түлш олборлох • металлург • химийн үйлдвэрлэл • машины үйлдвэрлэл • электроник
Татварын амралт: 3 жил 100%, 3 жил 50%	<ul style="list-style-type: none"> ◆ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 50-иас дээш хувийг экспортолж байвал
Татварын амралт: 1 жил 100%, 2 жил 50%	<ul style="list-style-type: none"> ◆ Орон нутгийн хөгжлөөс хамааран алслагдсан аймаг, сумдад шинээр үйл ажиллагаа эхэлсэн аж ахуйн нэгжид
Татварын амралт: 1 жил 100%, 2 жил 75%	<ul style="list-style-type: none"> ◆ Орон нутгийн хөгжлөөс хамааран алслагдсан аймаг, сумдад шинээр үйл ажиллагаа эхэлсэн аж ахуйн нэгжид
Татварын амралт: 2 жил 100%, 1 жил 50%	<ul style="list-style-type: none"> ◆ Орон нутгийн хөгжлөөс хамааран алслагдсан аймаг, сумдад шинээр үйл ажиллагаа эхэлсэн аж ахуйн нэгжид
Ерөнхий	<ul style="list-style-type: none"> ◆ татварыг сар бүрийн 25-ний дотор урьдчилан төлнө ◆ улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор тушаана ◆ жилийн тайланг дараа оны 2-р сарын 10-ны дотор тушаана

ШИНЭ ХУУЛЬ

Алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох	<ul style="list-style-type: none"> ◆ татварын тайлангийн алдагдлыг дараагийн 2 жилд шилжүүлэн тооцох: <ul style="list-style-type: none"> • жил бүр хасагдах алдагдлын хэмжээ нь тухайн жилийн албан татвар ногдуулах орлогын дүнгийн 50 хувиас хэтрэхээргүй байна • 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш гарсан алдагдал хамаарна
Татварын амралт: 10 жил 100%, 5 жил 50%	байхгүй
Татварын амралт: 5 жил 100%, 5 жил 50%	байхгүй
Татварын амралт: 3 жил 100%, 3 жил 50%	байхгүй
Татварын амралт: 1 жил 100%, 2 жил 50%	байхгүй
Татварын амралт: 1 жил 100%, 2 жил 75%	байхгүй
Татварын амралт: 2 жил 100%, 1 жил 50%	байхгүй
Ерөнхий	<ul style="list-style-type: none"> ◆ Татварын тайланг аккрузал сууриар бүртгэнэ ◆ татварыг сар бүрийн 25-ний дотор урьдчилан төлнө ◆ улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор тушаана ◆ жилийн тайланг дараа оны 2-р сарын 10-ны дотор тушаана



АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төслийн туслалцаатай бэлтгэн хэвлэв.